



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 40

Сэнхэр

Г Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, 42 дугаар зүйл, "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж үйлчилгээний тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга:	Р.Цоож	-Нийгмийн даатгалын байцаагч
Гишүүд:	О.Алтансүвд	-Халамж үйлчилгээний мэргэжилтэн
	Г.Мөнхтуул	-Нийгмийн бодлогын ажилтан
	Б.Дариймаа	-Сэнхэр багийн иргэн
	Н.Өлзийбаяр	-Борт багийн иргэн
	Э.Гэрэлмаа	-Сэнхэр багийн иргэн
	Я.Чимгээ	-Борт багийн иргэн

2. Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн 20 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн халамжийн бүх төрлийн үйлчилгээнд бүрэн хамруулах, ажлын байраар хангах талаар тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, хийсэн ажлын мэдээллийг жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг зөвлөлийн дарга /Р.Цоож/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 41

Сэнхэр

ГАмьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд 7
өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн халамжийн тухай Монгол улсын хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3 дахь заалтыг үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийнТөлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүнээс Б.Цэнгэлийг чөлөөлж, Сэнхэр багийн иргэн Дамчаа овогтой Маамбааг зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж өөрчилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР





ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 42

Сэнхэр

Г Агнуурын бүс нутаг тогтоох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Амьтны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ан агнуурын "Хүрэлдэй", "Борт" бүс нутгийн зураглал, хилийн цэсийг хавсралтаар баталсугай.


2. Энэхүү агнуурын бүс нутгийн менежментийг "Шаманистик" ХХК-д хариуцуулж, гэрээ байгуулан менежментийн гэрээнээс үндэслэн Угалз 1, Янгир тэх 3, бүгд 4 толгойг агнуулахыг Засаг дарга /Б.Батболд/-д даалгасугай.

3. Агнуурын бүс нутгийн хамгаалалтыг сайжруулах, ач холбогдлыг нь иргэдэд сурталчилан ойлгуулах, ан амьтныг хамгаалах, зохистой ашиглах, сэргээн нутагшуулах, тоо толгойн хэмжээг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулан хэрэгжүүлж, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батболд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР



Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр
сарын 07-ны өдрийн 42 дугаар тогтоолын
хавсралт



АГНУУРЫН БҮС НУТГИЙН ХИЛИЙН ЦЭС

1. Мөнххайрхан сумын Борт, Сэнхэр, Алаг багийн нутаг "Борт" агнуурын бүс нутгийн Өвөлжингийн Улаан хад, Хүрэлдэй уул, Бортын даваа, Дунд уул, Улиастын хөх уул, Улиастын гол, Хатуу сай, Алаг тэх гол, Алаг уул, Үет сант, Дунд Сэнхэрийн гол гэсэн уртраг 91,96672, өргөрөг 47,22977 солбицол хилийн цэсийг хамарсан 567,1 км² хавтгай талбайгаас Янгир тэх 3 толгойг,

2. "Хүрэлдэй" агнуурын бүс нутгийн Улаанбөөрөг, Гулзын толгой, Бортын гол, Цагаан таг, Хүрэлдэй уул, Мааньтын улаан гэсэн уртраг 92,15001, өргөрөг 46,94766 солбицол хилийн цэс хамарсан 547,5 км² хавтгай талбайгаас Угалз 1 толгойг тус тус агнуулах боломжтой.



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 43

Сэнхэр

Г Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний
төсөл дэмжих тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.3.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний төслийг хавсралтаар дэмжсүгэй.

2.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд Тэргүүлэгчдээс авсан саналыг тусган Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хугацаанд хүргүүлэхийг Газрын даамал /С.Оюун-эрдэнэ/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн
43 дугаар тогтоолоор дэмжив.



ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМЫН 2018 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хугацаа	Хариуцах эзэн
1	1.1. Газрын менежментийн мэдээллийг өргөтгөх замаар мэдээллийн сан бүрдүүлж, иргэдэд үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх	1.1.1. Газрыг гэр бүлийн хэрэгцээнд өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг цахим хэлбэрт оруулж газрын бүртгэл, зураглалтай холбож иргэдэд мэдээллээр үйлчлэх	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
		1.1.2. Сумын бүх байгууллагад хувийн хэргийг нээж, цаашид байнга хөтлөх заавар зөвлөгөө өгөх.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
		1.1.3. Газрын жижүүрийн зураг, хөтлөх ажлыг тогтмолжуулан шинээр олгогдох хашаа, өвөлжөө хаваржаа, тор зэргийг зурагт тэмдэглэн бүртгэх.	жилдээ	Газрын даамал
		1.1.4. Газрын тухай хуулийн дагуу 2 жил газраа эзэмшээгүй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын газрыг хүчингүй болгох эрх зүйн актыг тухай бүр гаргаж хэрэгжүүлэх	жилдээ	Сумын Засаг дарга, БОХУБ, Газрын даамал
		1.1.5. Кадастр шинээр хийлгэх газрыг айл өрхийн судалгаа гаргаж, кадастр хийлгэнэ.	жилдээ	Газрын даамал
2	2.1. Газрын татвар, төлбөр дуудлага, худалдаа, төсөл сонгон шалгаруулалт	2.1.1 Газар эзэмших ашиглаж буюу иргэн аж ахуй нэгжийн төлбөрийн ногдолтийг хийж төлбөрийг төвлөрүүлнэ.	жилдээ	Газрын даамал
		2.1.2 Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг ногдуулан, төвлөрүүлэх	жилдээ	Газрын даамал
		2.1.3 Газрын татвар төлбөрийн тайланг улирал бүр гаргаж, татварын хэлтэст хугацаанд тушаана.		Газрын даамал
		2.1.4 Хуулийн дагуу газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
3	3.1 Газар өмчлөл, эзэмшилтийн үйл ажиллагааг идэвхижүүлэх	3.1.1 Шинээр газар өмчлөх болон эзэмшиж байсан газраа өмчлөх иргэдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
		3.1.2 Хамтран өмчилсөн иргэдийн хүсэлтийг хүлээн авч, Нотариатч, Улсын бүртгэгчтэй хамтран ажиллана.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
		3.1.3 Газрын хэмжээ талбай өөрчилж, зөрчил арилгана хувийн хэргийн дугаарыг өөрчлөх, баяжилтийг хийж, цахимжуулна.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
		3.1.4 Өвөлжөө хаваржааны газрын цэгийг GPS-ээр авч, QGIS программд бүрэн оруулж, бүртгэлжүүлнэ.	жилдээ	Газрын даамал

4.1. Хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалт	4.1.1 Бэлчээр ашиглалтын нөлөөллийг фотомониторингийн аргаар хяналт, хийж бэлчээрийн газрын даац, ургац тогтоож, мэдээлийг сайжруулна	жилдээ	Газрын даамал, Бэлчээр хариуцсан мэргэжилтэн	
	4.1.2 Бэлчээрийн зүй зохистой ашиглан хамгаалах, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллаж, бэлчээр ашиглуулах гэрээ байгуулан зураглал гаргаж ажиллана.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал	
	4.1.3 Бэлчээр ашиглалтын бүлэгт Гэрээгээр хадлангийн талбайн газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал	
	4.1.4 Малчдын дунд бэлчээрээ хэрхэн хамгаалах, зүй зохистой ашиглах хамгаалах талаар хэлэлцүүлэг зохион байгуулах	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал	
5	5.1.1 ЗДТГ-ын болон бусад мэргэжилтэнгүүдтэй хамтран мэдээлэл сургалт зохион байгуулан ажиллана.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал	
	5.1.2. БИНХ-аар дамжуулан иргэдийн дунд Газрын тухай хуулийг сурталчлах	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал	
	5.1.3 Газрын харилцааны ажилтаны нэг өдрийг тохиолдуулан нээлттэй өдөрлөг зохион байгуулах	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал	
6	6.1 Тусгай хамгаалалт, болон тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт	6.1.1 Тусгай хамгаалалттай газар, тусгай хэрэгцээнд байгаа газрын мэдээллийг иргэдэд нээлттэй сурталчлан зурагт самбар хийж байршуулна.	жилдээ	Газрын даамал
		6.1.2. Тусгай хэрэгцээнд Ус цаг уурын усны харуулын газар, ажиглалтын талбайг тусгай хэрэгцээнд авсан тогтоол гаргана.	жилдээ	Газрын даамал УЦУОШГ
7	7.1 Зам шугам сүлжээний газрын төлөвлөлт	7.1.1 Цэнхэрийн гол дээр баригдах бага орврын усан цахилгаан станцын газрыг олгож, үйл ажиллагаанд хяналт хийнэ	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
		7.1.2 Шугам сүлжээний газрыг төлөвлөж, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.	жилдээ	Сумын Засаг дарга, Газрын даамал
8	8.1 Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулт	8.1.1 Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан удирдамж боловсруулан ажиллана.	жилдээ	Газрын даамал
		8.1.2 Баг иргэд, ААНБ-ын саналыг авч нэгтгэн сумаас хэрэгжүүлэх арга хэмжээг тусган сумын ГЗБ-ын жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж сумын Засаг даргад өргөн барина	жилдээ	Газрын даамал
		8.1.3 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт гаргаж, тайлан хэлэлцүүлнэ.	жилдээ	Газрын даамал

Нийт 8 бүлэг 23 зүйлийн ажил төлөвлөв.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН
ГАЗРЫН ДААМАЛ С.ОЮУН-ЭРДЭНЭ

Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дэмжив.




ИРГЭНД ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ШИНЭЭР ӨМЧЛҮҮЛЭХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

№	Багийн нэр	Байршил	Байршлын солбицол	Өрхийн тоо	Газрын хэмжээ	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа												Хариуцах эзэн
							I			II			III			IV			
							1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Сэнхэр	Дээд лагерьт Мөнхтөрийн зүүн талд		8	0.6	ГБХ	*	*	*	*	*	*	*	*	*	*	*	Засаг дарга, Газрын даамал	
2	Сэнхэр	доод лагерьт		5	0.4	ГБХ	*	*	*	*	*	*	*	*	*	*	*	Засаг дарга, Газрын даамал	
		Дүн		13	1	ГБХ													

Төлөвлөгөө боловсруулсан
Газрын даамал С.Оюун-Эрдэнэ

Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дэмжив.



1 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДЭВСГЭР ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ /2018 он/

№	Байршил	Талбайн солбицол	Газрын хэмжээ га	Зориулалт	Техникийн нөхцөл	Хэрэгжүүлэх хугацаа/улирал, сараар /				Хариуцах эзэн
						I	II	III	≥	
1	Сэнхэр	Төв гудамжинд / Цастхайрхан гудамжинд/ Нямдуламын дэлгүүрийн доод талд	50	дэлгүүр		*	*	*		Сумын Засаг Дарга, Газрын даамал
	Сэнхэр	Төв гудамжинд / Цастхайрхан гудамжинд/ Т.Лхагвадоржийн дэлгүүрийн дээд талд	80	дэлгүүр		*	*	*		Сумын Засаг Дарга, Газрын даамал
	Сэнхэр	Ямаат гудамжинд	600	Сүм хийд		*	*	*		Сумын Засаг Дарга, Газрын даамал
	Сэнхэр	Хуучин Захиргаа байгаа газарт / Сэнхэр багийн дээд лагерьт/	400	Ахмадын байр		*	*	*		Сумын Засаг Дарга, Газрын даамал

Төлөвлөгөө боловсруулсан
Газрын даамал С.Оюун-Эрдэнэ

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дэмжив .



ИРГЭНД ЭЗЭМШИЖ БАЙГАА ХАШААНЫ ГАЗРЫГ НЬ ҮНЭГҮЙ ӨМЧЛҮҮЛЭХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

№	Багийн нэр	Байршил	Байршлын солбицол	Өрхийн тоо	Газрын хэмжээ	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа												Хариуцах эзэн
							I			II			III			IV			
							1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Сэнхэр	Доод лагерьт		3	0.33	ГБХ	*	*	*	*	*	*	*	*	*	*	*	*	Засаг дарга, Газрын даамал
	Сэнхэр	Дээд лагерьт		6	0.65	ГБХ	*	*	*	*	*	*	*	*	*	*	*	Засаг дарга, Газрын даамал	
		Дүн		9	0.99	ГБХ												Засаг дарга, Газрын даамал	

Төлөвлөгөө боловсруулсан:
Газрын даамал С.Оюун-Эрдэнэ

Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дэмжив .



МӨНХХАЙРХАН СУМЫН ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ДООРХ ГАЗРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ

№	Багийн нэр	Эзэмшүүлэхээр төлөвлөсөн өвөлжөө, хаваржааны доорхи газар				Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Хариуцан хэрэгжүүлэх эзэн	
		Газрын оноосон нэр	Байршлын солбицол/эзэмшигчийн тоо/		Газрын хэмжээ /га/	Усан хангамжийн байдал	1	2	3		4
			Өвөлжөө	Хаваржаа							
1	Мөнххайрхан	Алаг	5	5	1.5	гол горхи	*	*	*	*	Сумын Засаг дарга, Газрын даамал, Багийн Засаг дарга
		Борт	5	5	1.5	гол горхи	*	*	*	*	Сумын Засаг дарга, Газрын даамал, Багийн Засаг дарга
		Хаг	5	5	1.5	гол горхи	*	*	*	*	Сумын Засаг дарга, Газрын даамал, Багийн Засаг дарга
		Сэнхэр	5	5	1.5	гол горхи	*	*	*	*	Сумын Засаг дарга, Газрын даамал, Багийн Засаг дарга
	Нийт		20	20	6						

Төлөвлөгөө боловсруулсан:
Газрын даамал С.Оюун-Эрдэнэ

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны
өдрийн 43 дугаар тогтоолоор дэмжив.



ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ДООРХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

№	Багийн нэр	Газрын байршил	Ашиглалтын зориулалт	Тавигдах шаардлагатай зам, шугам, сүлжээний төрөл				Хэрэгжүүлэх хугацаа / улиралаар/				Хариуцах эзэн	
				Хөлбооны шугам	авто зам /терөл ба км/	эрчим хүч /хүчин чадал ба км/	ус дулаан дамжуулах хоолой /км/	I	II	III	IV		
1	Сэнхэр баг	Хуурай хавцал, Доод Улаанговь	Цахилгаан дамжуулах шугам			30 км			*	*			Сумын Засаг дарга, Газрын даамал
2	Алаг баг	Цагаан сайгийн ам	Бага оврын усан цахилгаан станц			10 га /500квт/			*	*			Сумын Засаг дарга, Газрын даамал

Төлөвлөгөө боловсруулсан:

Газрын Даамал

С.Оюун-Эрдэнэ

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дэмжив.



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

№	Багийн нэр	Газрын нэр байршил	Зориулалт	Талбайн солбицол	Талбайн хэмжээ /га/	Тусгай хэрэгцээнд авах үндэслэл	Хэрэгжүүлэх хугацаа				Хариуцах эзэн
							I	II	III	IV	
1	Сэнхэр баг	Сэнхэр багийн төвд	Ус цаг уурын ажиглалтын талбай		0.13 га /1352м2/	ус цаг уурын орчны шинжилгээний үйл ажиллагаа явуулах ажиглах талбай	*	*	*	*	Сумын Засаг дарга, Газрын даамал, Ус цаг уур орчны шинжилгээний газар
2	Сэнхэр баг	Цэнхэрийн гол дээр	Усны харуулын талбай		0.6 га /630.5м2/		*	*	*	*	
3	Хаг баг	Улиастын гол	Усны харуулын талбай		0.3 га /3154м2/		*	*	*	*	
нийт дүн					0.51 га /5136 м2/						

Төлөвлөгөө боловсруулсан

Газрын даамал

С.Оюун-Эрдэнэ

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны
өдрийн 48 дугаар тогтоолоор дэмжив.



ГЭРЭЭГЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ ХАДЛАНГИЙН ТАЛБАЙ

№	Багийн нэр	газрын оноосон нэр	талбай га	БАХ-ийн нэр	Хэрэгжүүлэх хугацаа				Сайжруулалт хийх арга хэмжээ		
					I	II	III	IV	хийх ажил	хугацаа	хариуцах эзэн
1	Борт баг	Усан нийлдэг /Өргөн ширэг/	2 га	Арцат бүлэг		*	*		тор татаж хамгаалах	2, 3 дугаар улиралд	Арцат бүлэг, Төсөл хөтөлбөр
2	Сэнхэр баг	Завсар усанд Хөх булаг	2 га	Хүрэлдэй бүлэг		*	*		тор татаж хамгаалах	2, 3 дугаар улиралд	Хүрэлдэй бүлэг, Төсөл хөтөлбөр
Нийт дүн			4 га								

Төлөвлөгөө гаргасан
Газрын даамал С.Оюун-Эрдэнэ



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 45

Сэнхэр

Г Ой тэмдэглэхийг дэмжих тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн 12 жилийн сургуулийн захирал Б.Түвшинзоригийн өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын бүрэн дунд сургууль үүсэн байгуулагдсаны түүхт 70 жилийн ойг 2018 оны 7 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг дэмжиж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР





ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 46

Сэнхэр

Г Нэрэмжит болгох санал дэмжих тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.3-ыг үндэслэн Сургуулийн захирал Б.Түвшинзоригийн өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Мөнххайрхан сумын бүрэн дунд боловсролын сургуулийг тус сумын уугуул, анхны төгсөгч, Монгол улсын гавъяат багш, дугуйн спортын олон улсын хэмжээний мастер Гүнчингийн Дашганы нэрэмжит болгох саналыг уламжилсугай.

2.Орон нутгийн байгууллагыг нэрэмжит болгох санал, хүсэлт холбогдох баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргад хүргүүлж шийдвэрлүүлэхийг сумын Засаг дарга /Б.Батболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР





ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 47

Сэнхэр

Г Хуралдаан товлон зарлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 5 дугаар хуралдааныг 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн "Пүрэв" гарагт сумын төвд хуралдуулахаар товлон зарласугай.

Хоёр. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1/ Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн дүн, сумын ИТХ-ын Төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай илтгэл

2/ Сумын ИТХ-ын 2017 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай илтгэл

3/ Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай илтгэл.

4/ Сумын 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийн өөрчлөлт, 2017 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсвийн төслийн тухай илтгэл

5/ Сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2018 оны төлөвлөгөөний тухай илтгэл

6/ Хүрэлдэй, Арцат малчдын бүлгийн хариуцан хамгаалж буй талбайн ан, амьтан хамгаалах тухай хүсэлт

7/ Тусгай зориулалтаар агнуулах агнуурын амьтны төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох тухай илтгэл

Гурав. Хуралдаанаас гарах шийдвэрийн төслүүдийг боловсруулан бэлэн болгож, хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулалт сайтай хуралдуулахыг нарийн бичгийн дарга /О.Бишгарам/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР



D; Togtool:2017.11.20